

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт
үлдээдлийг арилжааны банканд
байршуулах мөнгөн хадгаламжийн
хүүгийн доод хэмжээг тогтоох тухай*

2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.8 “Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс тооцсон жигнэсэн дундаж хүүгээс доошгүй байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

1. Монголбанкны бодлогын хүү, банк хооронд хийгдсэн барьцаагүй овернайт хэлцлийн жигнэсэн дундаж хүү:

Монголбанкны бодлогын хүү, банк хооронд хийгдсэн барьцаагүй овернайт хэлцлийн жигнэсэн дундаж хүү 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойших хугацаанд тогтмол 13 хувьтай байна.

Банк хоорондын овернайт арилжааны дундаж /MONIA/ индекс



*MONIA индекс нь банк хооронд хийгдсэн барьцаагүй овернайт хэлцлийн жигнэсэн дундаж хүү юм. Хэрэв тухайн өдөр банк хоорондын захад овернайт хэлцэл хийгдээгүй тохиолдолд хамгийн сүүлд овернайт хэлцэл хийгдсэн өдөр тооцогдсон MONIA индексийг хүчинтэйд тооцно.

2. Арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ:

Тайлант сарын үлдэгдлээрх нийт харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү*
Жилийн хүү, хувиар

Хугацааны эцэст	Нийт (i,ii)	i) Хугацаагүй	ii) Хугацаатай	Хадгаламж Төрөг									2023 оны 10 сар
				Үүнээс:									Харилцах
				3 сар хүртэг	4-6 сар	7-9 сар	10-12 сар	13-18 сар	19-24 сар	25-36 сар	36-с дээш сар	Төрөг	
2023	01	10.2	6.2	10.9	9.5	10.2	11.7	12.4	10.3	12.9	12.4	11.4	0.0
	02	10.4	6.0	11.1	9.7	10.5	12.3	12.4	10.6	13.1	12.4	11.4	0.7
	03	10.5	6.2	11.3	9.9	10.6	12.8	12.5	10.9	13.3	12.5	11.4	0.7
	04	10.7	6.3	11.5	10.1	11.5	12.7	12.6	11.8	13.0	12.4	11.4	0.8
	05	10.7	5.9	11.7	10.2	12.0	12.7	12.7	12.2	13.1	12.4	11.4	0.8
	06	10.9	6.2	11.8	10.2	12.4	12.6	12.7	12.4	13.7	12.4	11.4	0.6
	07	11.0	6.2	12.0	10.9	12.3	12.7	12.7	12.6	13.6	12.4	11.4	0.6
	08	11.2	6.2	12.1	11.4	12.3	12.7	12.8	12.6	13.7	12.4	11.4	0.6
	09	11.3	6.2	12.2	11.7	12.2	12.7	12.8	12.8	13.8	12.4	11.4	0.6
	10	11.3	6.1	12.3	11.5	12.4	12.7	13.2	12.8	13.8	12.4	11.4	0.7

* - Хүүний тооцоолдолд төсөвт байгууллага болон эдийн засгийн харьяат бусын харилцах, хадгаламжийг оруулж тооцдоггүй.

** - "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт "Цар тахлын үед банкны харилцах данс болон хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй" байхаар зохицуулсантай холбоотойгоор 1) 2020.04.29-2022.12.31 өдрийг дуустал харилцах дансанд, 2) 2021.01.29-2022.12.31 өдрийг дуустал бүх төрлийн хугацаагүй хадгаламжид тус тус хүү тооцогдохгүй.

3. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээ:

Арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээнээс тооцсон жигнэсэн дундаж хүү **13.07** хувь байна.

№	Үзүүлэлт	Хүүгийн хэмжээ/ Хувиар/
1	Монголбанкнаас зарласан бодлогын хүү	13
2	Банк хооронд хийгдсэн барьцаагүй овернайт хэлцлийн жигнэсэн дундаж хүү	13
3	Арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүү	13.2
4	Жигнэсэн дундаж хүүгийн хэмжээ	13.07

---oOo---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны
банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны
хүүгийн доод хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар
зүйлийн 13.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд
байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны хүүгийн доод хэмжээг 13.07 хувиар
баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын
ерөнхий газар (Л.Мөнхзул)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын
үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

Гарын үсэг